



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/372

Хэрлэн сум

Эрх бүхий албан тушаалтны
баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын орон нутагт ажилласан багаас өгсөн зөвлөмжийн дагуу Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хангах, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн байгууллагын Эрх бүхий албан тушаалтнуудын хууль тогтоомжийн мэдлэг, цахим бүрдүүлэлтийн программ дээр ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Эрх бүхий албан тушаалтны багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|----------------------|---------------|---|
| Багийн ахлагч: | Ж.Гантулга | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, ЭБАТ |
| Багийн нарийн бичиг: | Н.Үнэнбат | -Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн, ЭБАТ |
| Багийн гишүүд: | П.Батжаргал | -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын захиргаа, хяналтын хэлтсийн дарга, ЭБАТ |
| | П.Ариунбаатар | -Боловсрол соёл урлагийн газрын мэргэжилтэн, ЭБАТ |
| | Ц.Туяасайхан | -Мэргэжлийн хяналтын газрын ахлах мэргэжилтэн, ЭБАТ |
| | Д.Уламбаяр | -Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын мэргэжилтэн ЭБАТ |

2//.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж, Эрх бүхий албан тушаалтны багийн гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга бөгөөд багийн ахлагч /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА